

“ЧОНОХАРАЙХ ГОЛ” ХХК

**“ЧОНОХАРАЙХ ГОЛ” ХХК-ИЙН СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦАГААН СУМЫН 1-Р БАГИЙН НУТАГТ БАЙРЛАХ
“ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

РД: 3673952

УЛААНБААТАР ХОТ 2025 ОН

ГАРЧИГ

ГАРЧИГ	1
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн товч тодорхойлолт:	3
1.2 Төслийн байршил:	8
1.3 Төсөл хэрэгжих дэд бүтцийн байдал	11
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
2.1. Төслийн физик газарзүйн нөхцөл	12
2.2 Цаг уур, уур амьсгал	12
2.3 Гадаргын ус	12
2.4 Газар доорхи ус	13
2.5 Хөрсөн бүрхэвч	14
2.6 Ургамлан нөмрөг	17
2.7 Амьтны аймаг	17
2.8 Тусгай хамгаалалттай газар нутаг	17
2.9 Нийгэм, эдийн засаг	20
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	24
3.1 Нүүрс ачиж буулгах үеийн тоосжилтоос үүсэх гол сөрөг нөлөөлөл	24
3.2 Барилга байгууламжийг өргөтгөн барьж ашиглалтад оруулснаас хойших үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл	25
3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	26
3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл	27
3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл	27
3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	28
3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	28
3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл	28
3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	29
3.10 Хуримтлагдах нөлөөлөл	29
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	30
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
ЗУРГАА.ОРЧНЫ ТОХИЖИЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	33
НАЙМ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	35
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	35

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	37
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	38

ТАЙЛАНД ОРУУЛСАН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газарзүйн солбицол.....	8
Хүснэгт 2. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл.....	15
Хүснэгт 3. Төслийн талбайн ойролцоох Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	18
Хүснэгт 4. Багийн өрхийн мэдээлэл, хүн ам.....	22
Хүснэгт 5. Багийн малчин өрхийн тоо	22
Хүснэгт 6. Сумын мал аж ахуйн үзүүлэлтүүд.....	23
Хүснэгт 7. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа	24
Хүснэгт 8. Гол нөлөөллийн дүн шинжилгээ.....	24
Хүснэгт 9. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ	26
Хүснэгт 10. Автомашины утааны бүрдэл найрлага	26
Хүснэгт 11. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл.....	29
Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	31
Хүснэгт 13. Хог хаягдлын ангилал, зэрэглэл.....	Error! Bookmark not defined.

ТАЙЛАНД ОРУУЛСАН ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Засаг захиргааны зураг	9
Зураг 2.Төслийн байршлын агаар сансрын зураг.....	9
Зураг 3. Төслийн талбайн байршлын зураглал.....	10
Зураг 4. Төслийн талбайн хээрийн ажлын зураг /2023.11.10 өдрийн байдлаар/	10
Зураг 5. Төслийн талбайн харагдах байдал 2023 оны 11 сарын 10 өдөр	11
Зураг 6. Төслийн талбайн орших сав газрын зураглал	14
Зураг 7. Төслийн хөрсөн бүрхэвчийн зураглал	15
Зураг 8.Хөрсний эвдрэлийн зураглал.....	16
Зураг 9. Төслийн талбайн бэлчээрийн хэв шинж.....	17
Зураг 10. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний зураглал.....	18
Зураг 11. ОНТХГН-ын сүлжээ	20
Зураг 12.Эрдэнэцагаан сумын нутгийн удирдлагын ордон	22


НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: “Гаалийн хяналтын талбай” төсөл

1.1 Төслийн товч тодорхойлолт:


Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	“Чонохарайх гол” ХХК РД:3673952 ХХД:1211001131 Тус компани нь гадаад дотоод худалдаа, олон улсын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2019 онд байгуулагдсан.
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн байршил	Сүхбаатар, Эрдэнэцагаан, 8-р баг, Алтан Овоо, Худалдааны 3 гудамж 7 тоот Утас: 99909066
1.3	Ерөнхий үнэлгээний дүгнэлт	БОАЖЯ-ны 2024 оны 01 сарын 24-ны өдрийн 12/402 тоот Ерөнхий үнэлгээний дүгнэлт

Хоёр. Төслийн талаарх мэдээлэл

2.1	Төслийн нэр	“Гаалийн хяналтын талбай”
2.2	Төслийн байршил	<p>Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 1-р багийн Бичигтийн боомтод байрлах ба нүүрс тээвэрлэх төв авто зам дагуу 59161.7 м.кв талбайг хамарна.</p> 
2.3	Төслийн үндэслэл	Экспортын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, уул уурхайн компаниудын ажилт, буулгалтыг түргэсгэх.
2.4	Төслийн зорилго	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 1-р баг Бичигт боомтод тус сумын Засаг даргын 2023 оны 10 сарын 31 өдрийн А/235 тоот захирамжаар 7.1 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшихээр авсан болно. Эрдэнэцагаан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 01 сарын 26-ны өдөр 59161.7 мкв талбайг төлөвлөж өгсөн. Тус компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй гаалийн хяналтын талбайн төсөл хэрэгжиж эхэлснээр:

“Чонохарайх гол” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 1-р багийн нутагт байрлах
“Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн
төлөвлөгөө

		<ul style="list-style-type: none"> • Ажлын байр нэмэгдэнэ. • Нүүрсний эскпортын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, уул уурхайн компаудын ачилт, буулгалтын түргэгсэх
2.5	Төслийн ерөнхий төлөвлөгөө	<ul style="list-style-type: none"> - Талбайн баруун болон хойд хэсгийг 6 метрийн өндөртэй, багана хооронд 6 метрийн урт, 0.3см диаметрийн нүхтэй нимгэн төмөр хашаагаар хашаалсан. Зүүн болон урд хэсгийг 2 метрийн өндөртэй, багана хооронд 3 метрийн урттай төмөр торон хашаагаар хашаалсан. - Нүүрс ачиж буулгах талбайд 6 метрийн өндөртэй хашаа болон 6 метрийн өндөртэй 12 ширхэг бетонон шонгууд дээр эрчим хүчний хэмнэлттэй 400W LED гэрэл 23 ширхэг, 150W LED гэрэл 10 ширхгийг тус тус суурилуулсан. - Хяналтын бүсийн цахилгааны тэжээлийн эх үүсвэрийг 100Кв гаргах хүчин чадалтай WECNAI мотортой 2 ширхэг дизель генератораар шийдвэрлэсэн. Төвийн шугамд холбох 10Кв-ийн трансформаторыг байрлуулж бэлтгэл ажлыг хангасан. - Hikvision брэндийн 16 ширхэг IP камерыг холбогдох стандартын дагуу монтажлан суурилуулж, ГЕГ-ийн Genetic системд холбосон. - ХК3190-А9 загварын 21 метрийн урттай 3.4 метрийн өргөнтэй 50 кг-ийн нарийвчлалтай, 150 тонн хүртэлх ачааг жинлэх хүчин чадалтай авто жин 1 ширхэг, - D2008 загварын 40 метрийн урттай 3.2 метрийн өргөнтэй 50 кг-ийн нарийвчлалтай, 200 тонн хүртэлх ачааг жинлэх хүчин чадалтай авто жин 1 ширхэг тус тус суурилуулан, Стандартчилал хэмжилзүйн улсын хяналтаар баталгаажуулсан. - ГЕГ-ийн Genetic системтэй Мобинет ХХК-ийн өндөр хурдны (5 Mbps) VPN үйлчилгээгээр холбогдсон ба өндөр хурдны интернэтийн үйлчилгээг тус компанийн Dedicated 3Mbps урсгалаар гэрээ байгуулан авсан байна. - Авто дүүлэгч, гаалийн байцаагчийн ажлын шаардлага хангасан 2 ширхэг байр бэлдсэн - Нүүрсний зам ба талбайг холбосон сайжруулсан шороон зам, талбай дотор машин явах дайрга бүхийг сайжруулсан зам, зогсоолыг зассан. - Нүүрсний овоолго хийх бий болгох газрыг нүүрсний хучилт хийж бэлтгэсэн. - Гаалийн хяналтын бүсэд таних тэмдэг бэлдэж байрлуулах - Гаалийн хууль тогтоомж, хяналтын бүсэд мөрдөгдөх дэглэмийн тухай мөн галын анхааруулах самбарууд байрлуулах.
2.5	Төслийн хүчин чадал	<ul style="list-style-type: none"> ✚ Тус гаалийн хяналтын талбай бүрэн хүчин чадлаараа ажиллахад 1 сард дунджаар 150 мянган тонн хүртэлх нүүрс хүлээн авч, гаалийн бүрдүүлэлт хийн ачиж өгөх боломжтой. ✚ Тус байгууллага нь хүний нөөцийн баг болон техник, технологийн нөөц баазыг хангалттай хэмжээнд бүрдүүлж чадсан бөгөөд байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүч, байнгын ажлын байртай албан хаагч, тэдгээрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, нийгмийн хангамжийн асуудлыг бүрэн шийдсэн кемп, засвар үйлчилгээний цэгийг барьж байгуулахаар төлөвлөж байна.
2.6	Төслийн хог хаягдал	<p>Хатуу хог хаягдал:</p> <p>Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 25.8 кг, жилд 9.03 тн орчим хаягдал гарах бөгөөд ангилан ялгаж пресслэж устгах, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэх болно.</p> <p>Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.</p> <ul style="list-style-type: none"> ✚ Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт ✚ Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй

		<p>бусад хог хаягдлууд</p> <p>✚ Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна. <i>Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай</i></p>  <p>Шингэн хог хаягдал:</p> <p>Ахуйн шингэн хог хаягдлын тооцоогоор хоногт нэг ажилтан зөврөөр хангагддаг тохиолдолд усны нормын дагуу өдөрт 80 литр бөгөөд нийт 30 ажилтан хоногт 2.4 м³ ус ашиглах ба усалгаа болон ногоон байгууламжид хоногт 3120м³, жилд 350 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 3960.0 м³/жил, үүнээс ахуйн хэрэгцээний 70%-ийг хаягдал ус гэж үзвэл 2772 м³/жил дахин ашиглах болно.</p> <p>Төслийн бохир усыг “Эколосс” ХХК-ний оруулж ирдэг бага оврын бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглахыг зөвлөж байна. /БОМТ-нд 16 сая.төг зардлыг тусгав/</p> <p>Хийн хаягдал:</p> <p>Төслийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.</p> <p>Төслийн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 493.9 тн дизель түлш зарцуулахад хөө – 22.96 тн, СО-0.000148 тн, нүүрстөрөгч–0.000445 тн, NO₂–0.00005927 тн, SO₂-0.00002963тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 22.96 тн хорт хий ялгарахаар байна.</p> <p><i>/Мэргэжлийн хяналтын агаарын хяналт шинжилгээ хийлгэж байх шаардлагатай./</i></p> <p><u>Аюултай хог хаягдал</u></p> <p>Харин тослох материал нь химийн гаралтай шингэн хаягдал болон хөрс бохирдуулагч эх үүсвэр болдог тул ажилласан тос /Хайби ойл ХХК/, аккумулятор /Үлэмж хүдэр ХХК/ болон хаягдал дугуй /Инахас ХХК/ дахин боловруулдаг үйлдвэрүүдэд нийлүүлэхийг зөвлөж байна. <i>/Хавсралтаар хамтран ажиллах гэрээ хавсаргав./</i></p> <p>Ашигласан тос, масло материалыг зориулалтын хамгаалалт бүхий нөөцийн 1 тн-ийн зориулалтын саванд хийж хураан хүргэж өгөх шаардлагатай.</p>
2.7	Ариун цэврийн байгууламж	Тус үйлдвэр нь нэгдсэн дотоод ариун цэврийн өрөө гаргаж хангах, хаягдал бохир усыг цэвэршүүлэх орчин үеийн хамгийн сүүлийн байгаль орчинд хор нөлөөгүй дэвшилтэт технологи хэрэглэнэ.
2.8	Усан хангамж	✚ Төслийн газрын цэвэр усны хангамжийг гүний худгаас гэрээтээр хангана. ✚ Төслийн үйл ажиллагааны эхэнд дулаан, унд ахуйн болон ахуйн хаягдал бохир усыг доор тусгасанаар шийдэх

“Чонохарайх гол” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 1-р багийн нутагт байрлах
“Таалийн хяналтын талбай” төслийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн
төлөвлөгөө

2.9	Цахилгаан хангамж	✚ Цахилгааныг төвийн шугамтай холбоход бэлтгэн 10Кв-ийн трансформаторыг бэлтгэсэн бөгөөд холбогдох хүртэлх цахилгааны хэрэглээг 100Кв гаргах хүчин чадалтай WECNAI мотортой 2 ширхэг дизель генератораар шийдвэрлэсэн.
2.10	Дулаан хангамж	✚ Тус байгууламж нь цахилгаан халаагуураар дулааныг хангаж, ялтсан бойлероор халуун усыг шийдвэрлэсэн.
2.11	Төслийн үргэлжлэх хугацаа	5 жил
Гурав. Нарийвчилсан үнэлгээний талаар		
3.1	Төслийн гол болон сөрөг нөлөөлөл	<p>Гол нөлөөлөл: Тус төсөл хэрэгжсэнээр хүний эрүүл мэнд, агаар болон хөрс ургамлын бүрхэвчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тоосжилт болон хийн хаягдал агаар орчныг бохирдуулж болзошгүй, - Шатах тослох материал учраас галын осол гарах эрсдэлтэй, - Хүний эрүүл мэндэд амьсгалын замаар хордож болзошгүй, - Шатах тослох материал асгарсны улмаас хөрс, гүний ус, бичил ан амьтан устах зэрэг аюултай, - Усны хэт их хэрэглээг зохистой хязгаарлах, хаягдал хуванцар ашиглан дуслын систем байгуулах, саарал ус ашиглах - Хүнд даацын машинууд олноор төвлөрөн бөөгнөрөх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнтэй уялдан хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх - Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал ихсэх. - Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах үед 4.0 га эдэлбэр газар, хөрс эвдрэлд орох, ургамал талхлагдана. - Шингэн хаягдал замбараагүй хаявал агаар болон хөрс, хөрсний ус, ургамал бохирдох
3.2	Сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж, шийдэл, технологийн хувилбар г.м	<p>Дээрх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тайлангийн 4 дугаар бүлэг болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн хүрээнд ногоон технологи ашиглах тухай зөвлөмж • Хатуу хог хаягдлын түр цэг байгуулах болон зориулалтын хогийн савыг ашиглах зөвлөмж • Аюултай хог хаягдлын хадгалах цэг байгуулах, дахин боловсруулдаг үйлдвэрт нийлүүлэх <i>/хавсралтаар хамтран ажиллах гэрээ оруулав/</i> • Шингэн хог хаягдлын цэвэршүүлэх байгууламж байгуулах зөвлөмж • Тамхи татах цэг байгуулах, • Талбай доторх зам болон зогсоолыг дайрган эсвэл эко хавтан болгох • Тоосжилтыг бууруулах арга хэмжээ – хурд хязгаарлах, 6 метр өндөр торон хашаа байгуулсныг сэргээн засварлаж • Ногоон байгууламж байгуулах зөвлөмж- сухайгаар дотор хашаа тойруулан тарих <p>Агаарын чанар: Сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тоосжилтын эх үүсвэрүүдийг услах, машины хурдыг хязгаарлах, эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх, шатах тослох материал бодисын асгарч алдагдахаас сэргийлэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсад мөрдөгдөж буй утаа, бохирдол болон олон улсын холбогдох MNS 4226:2000 “Агаарын чанар. Ерөнхий ухагдахуун, хэмжих нэгж”, MNS 4585:2007 “Агаарын орчны чанарын үзүүлэлт, ерөнхий шаардлага”, MNS 5014:2009 “Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга” тус тус стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлэх, үйлчилгээнд ашиглагдах тээврийн хэрэгслүүдэд тогтмол засвар үйлчилгээ хийх, чанартай шатах тос материал, утааны шүүлтүүр ашиглах арга хэмжээг авч</p>

	<p>хэрэгжүүлэх, 6-12 метрийн өндөртэй 0.3 см нүхтэй нимгэн төмөр тортой хашааг 1800 метр урт байгуулах, говийн нөхцөлд тохиромжтой сухай модоор 1800 ш хашаалж ногоон байгууламж бий болгох. <i>Байгаль орчны аудитын үнэлгээг 2 жил тутамд хийлгэх шаардлагатай.</i></p> <p>Гүний ус: Хөрсний орчинд шатах тослох материал алдагдахаас урьдчилан сэргийлж дайрган зам болгох, бохир усыг цэвэршүүлэн тоосжилт, ногоон байгууламжийн усалгаа зэрэгт эргүүлэн ашиглах, мөн гүний ус ашиглалтыг хянах, хамгаалах, хэрэглээг багасгах, гүний усны цооног болон гүний худгийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг орно. Асгарсан ШТМ-ыг яаралтай цуглуулан авч саармагжуулах, устгах, аргачлалын тухай сургалт хийх</p> <p>Хөрс: Энэхүү төслийг нийт 5.9 га талбайд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба уг төсөл хэрэгжих талбайн ойр орчмын газар нөлөөлөлд өртөхөөр байна. Иймээс авто тээврийн хэрэгслийн зогсоолыг цардаж цементлэхийн өмнө 3-5 см зузаантай наанги /шавар/ шороо дэвсэж нягтруулан индүүдэж авто тээврийн хэрэгслийн бохир тос, бензин үл нэвчүүлэгч /экрэн/ хаалт хийж өгөх, автомашины тос, бензин хөрсөн бүрхэвчийг бохирдуулахаас хамгаалах шаардлагатай. Төслийн талбайн шимт өнгөн хөрсийг төсөл эхлэхээс өмнө хуулж овоолон дараа нь нөхөн сэргээхэд ашиглах, хөрсний эвдрэлийг аль болох бага байлгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг цаг алдалгүй хийх, ахуйн болон үйлдвэрийн хуурай болон шингэн хог хаягдалыг цаг хугацаанд нь зайлуулах, төслийн төлөвлөгдсөн талбайгаас гадна машин техник байрлуулахгүй байх тал дээр анхаарах зэрэг орно. Аюултай хог хаягдлыг /хүнд машин механизмаас гарах хаягдал тос масло, аккумулятор, дугуй/ ажилласан тос, аккумулятор болон хаягдал дугуй дахин хүлээн авдаг үйлдвэрт /Оргил Баялаг Мандах ХХК/ нийлүүлэхийг зөвлөж байна. /Хавсралтаар хамтран ажиллах гэрээ хавсаргав/. Ашигласан тос, масло материалыг зориулалтын хамгаалалт бүхий нөөцийн 1 тн-ийн зориулалтын саванд хийж хураан хүргэж өгөх шаардлагатай.</p> <p>Ургамал: MNS 5918:2008 “Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” стандартын дагуу хэлбэржүүлж, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх, машин, өөрөө явагч хэрэгслийн хөдөлгөөн, нөлөөллийг тухайн тогтоогдсон зурваст байлгах арга хэмжээ авах, өнгөн хөрсийг тусгайлан хуулан авч тухайн газрын ойролцоо овоолго үүсгэн “Байгал-М” Био бэлдмэл ашиглан хадгалж, сүүлд нь тухайн газрыг нөхөн сэргээхэд ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаануудыг цаг алдалгүй хийх зэрэгтэй ба хаврын салхи шуурганы үеэр өнгөн хөрсний алдагдал ихэсдэгийг анхаарч ажлаа зохицуулах мөн тоос дарах ажиллагааг тогтмол хийж байх зэрэг болно.</p> <p>Амьтан: Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй, харин тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэлтэй ан амьтад дайжих хандлагатай. Иймд MNS ISO 226:2003 “Дуу чимээ-хэвийн норм-түвшний хэмжээ” стандартын дагуу тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэх, дуу чимээний нөлөөлөл зэргээс хөрсний амьтад устаж болзошгүй.</p> <p>Нийгэм эдийн засаг: Оршин суугч иргэдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тээврийн машинуудад дуу чимээний холбогдох стандартуудыг дагаж мөрдөх шаардлагыг тавьж хэрэгжүүлэх, үйл ажиллагаанаас гарах тоосжилтыг бууруулах, хүнд даацын машин механизмын дуу чимээг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, оршин суугч иргэдийг ажлын байраар хангах, Орон нутгийн ТББ-тэй хамтарч байгаль орчноо хамгаалах сургалт явуулах, ногоон бүс байгуулах, худаг булаг шанд хамгаалах зэрэг ажлуудад иргэдийг хамрагдах боломж олгох мөн голын болон худгийн усанд тогтмол хяналт шинжилгээ хийх зэрэг болно.</p>
--	---

**“Чонохарайх гол” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 1-р багийн нутагт байрлах
“Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн
төлөвлөгөө**

3.3	Эрсдлийн үнэлгээ, стандарт, урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмж	Эрсдлийн үнэлгээ нь төлөвлөгдөөгүй үйл явдлуудын нөлөөллүүдийг магадлал болон үр дагаваруудын эрчмийн хувьд авч үзэхийг зорьдог. Үр дагаварууд нь нөлөөлөлд өртөх хүмүүст ерөнхийдөө амь нас, гэмтэл, өвчлөл зэргээр харин орчинд сөрөг нөлөө хэлбэрээр илэрнэ. Төслийн үйл ажиллагаатай холбоотой гэнэтийн эрсдлүүд барилгын ажлын үе шат болон ашиглалттай холбоотой эрсдлүүд юм. Төлөвлөсөн бүх хяналт менежментийн арга хэмжээнүүд, хөдөлмөр хамгаалалтыг чанд хэрэгжүүлсэн тохиолдолд, хэвийн ажиллагаатай нөхцөлд онцгой сөрөг нөлөө байхгүй.
Дөрөв. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		
4.1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, ОХШХ, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, бусад зардал	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 5 жилд нийт 66600.0 мян.төгрөгийг төлөвлөж өглөө.
Тав. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн дүгнэлт		
5.1	Дүгнэлт	Байгаль орчин болон нийгэм-эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 50.0% нь бага буюу нөлөөлөлгүй, 22.8 хувь нь эерэг, 27.2 % нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна. Төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан тодорхойлогдоогүй сөрөг нөлөөллийг тухай бүрт нь илрүүлж, бууруулах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) болон орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-г тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай. Тус төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хүрээнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, нөлөөллийг бууруулах арга хэмжээ, эрсдэлийн үнэлгээ, түүний менежмент, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэргээр хянагдан зохицуулагдаж, зөвшөөрөгдөхүйц хэм хэмжээнд байж болохыг харгалзан үзэж уг төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой гэж үзэж байна.

1.2 Төслийн байршил:


“Гаалийн хяналтын талбай” төслийн талбай нь засаг захиргааны харьяаллын хувьд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 750 км-г, Баруун-Урт хотоос зүүн урагш 250 км, Эрдэнэцагаан сумаас зүүн тийш 65км-г 1-р багийн нутагт оршино. Төслийн талбай нь 1:100 000 масштабтай байр зургийн L-50-49 тоот хавтгайд орших бөгөөд нийт 7.1 га талбайг хамарна.

Хүснэгт 1. Газарзүйн солбицол


№	Өргөрөг			Уртраг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	45	45	48	116	11	41.2
2	45	45	56.7	116	11	36.7
3	45	45	56.9	116	11	36.7
4	45	45	57.9	116	11	43.4
5	45	45	57.9	116	11	45.3

**“Чонохарайх гол” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 1-р багийн нутагт байрлах
“Таалийн хяналтын талбай” төслийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн
төлөвлөгөө**

6	45	45	55.8	116	11	51.6
7	45	45	51.9	116	11	53.9



Зураг 1. Засаг захиргааны зураг



Зураг 2. Төслийн байршлын агаар сансрын зураг



Зураг 3. Төслийн талбайн байрилын зураглал



Зураг 4. Төслийн талбайн хээрийн ажлын зураг /2023.11.10 өдрийн байдлаар/



Зураг 5. Төслийн талбайн харагдах байдал 2023 оны 11 сарын 10 өдөр

1.3 Төсөл хэрэгжих дэд бүтцийн байдал

1.3.1 Цахилгаан хангамж

Цахилгааныг төвийн шугамтай холбоход бэлтгэн 10Кв-ийн трансформаторыг бэлтгэсэн бөгөөд холбогдох хүртэлх цахилгааны хэрэглээг 100Кв гаргах хүчин чадалтай WECNAI мотортой 2 ширхэг дизель генератораар шийдвэрлэсэн.

1.3.2 Усан хангамж

Цэвэр усны хангамжийг гүний худагас гэрээтээр хангадаг. /Хавсралтаар худгийн паспорт, гэрээ оруулав/ Гэрээт худаг нь төслийн байрнаас 13 км зайтай байрладаг бөгөөд эрүүл ахуйн бүсийн шаардлага хангаж байна.

1.3.3 Зам харилцаа

Зам, уулзвар шинээр гаргаж ажиллах зөвшөөрлийг авч ажиллах шаардлагатай.

1.3.4 Дулаан хангамж

Тус байгууламж нь ахуйн хэрэглээний цахилгаан халаагуураар дулааныг хангаж, ялтсан бойлоор халуун усыг шийдвэрлэсэн.

1.3.4 Харилцаа холбоо

Өндөр хурдны интернэтийн үйлчилгээг Мобинет компанийн Dedicated 3Mbps урсгалаар гэрээ байгуулан авсан байна.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн физик газарзүйн нөхцөл

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг нь физик газарзүйн мужлалаар Монгол Дорнод талын их муж, Халхын дундад ба Дарьгангын талархаг муж, Дарьгангын тэгш өндөрлөг талархаг тойрогт хамаарагдах бөгөөд гадаргын ерөнхий тогтоц нь нам бэсрэг уулс, тэдгээрийн хоорондох хөндий, толгодорхог тал хөндий, зарим хэсэгтээ нам хотосын шинжтэй өргөн хөндийнүүдээс бүрддэг.

Уулсын хажуу бэлээр чулуурхаг хээр зонхилоно. Сумын нутаг дэвсгэр нь далайн түвшнөөс дээш 750-1600 м өндөрт өргөгдсөн бөгөөд хамгийн өндөр цэг нь Ар булгийн баруун уул /1318.0 м/, хамгийн нам цэг нь Сайн хөөвөрийн уурхайн зүүн захын Уушигийн тал орчимд /860.0 м/ юм.

Тээвэрлэлт хийх нутаг дэвсгэрийн орчимд Бүдүүн уул /1334.0 м/, Баян уул /1019.0 м/, Уушигийн уул /910.0 м/ зэрэг уулс, тэдгээрийн хооронд болон завсараар Хошууны говь, Хүрэн булгийн хөндий, Хуцын гол, Монголын буян гол, Уушигийн тал зэрэг газрууд оршдог байна.

Тус талбай нь засаг захиргааны харьяаллын хувьд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумыг нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 750 км-т, Баруун-Урт хотоос зүүн урагш 250 км, Эрдэнэцагаан сумаас зүүн тийш 65км-т 1-р багийн нутагт оршино. Төслийн талбай нь 1:100 000 масштабтай байр зүйн зургийн L-50-49 тоот хавтгайд орших бөгөөд нийт 5.9 га талбайг хамарна

2.2 Цаг уур, уур амьсгал

Төслийн талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилд унах хур тунадасны хэмжээ 235.0 мм орчим бөгөөд хур тунадасны ихэнх нь 7, 8, 9-р саруудад ихэвчлэн уулархаг нутгаар унадаг. Дэлхийн дулааралтай холбоотойгоор талбайн хэмжээнд сүүлийн жилүүдэд жилд унах хур тунадасны хэмжээ 30-50 мм-ээр багасаж байгаагийн улмаас орон нутгаар гандуу болж өвс ургамлын гарц эрс муудаж байна.

Жилийн дундаж температур +1.8⁰С, хамгийн дулаан нь улирал нь 7, 8-р сард +20⁰С, хамгийн хүйтэн үе нь 1-р сард – 19⁰С хүрдэг. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба салхины хурд дунджаар 1-2 м/с байх ба хамгийн их салхи шуургатай улирал нь 5-6 сард болдог. Энэ үед салхины хурд 10 м/с-ээс дээш салхилна. Зарим жилүүдэд тухайлбал 2008 онд байгалийн гамшиг болоход цасан болон шороон шуурга 5-6 хоног үргэлжилсэн ба салхины хурд 25-28 м/с хүрсэн тохиолдол тэмдэглэгдсэн.

Судлагдсан талбай нь Монгол орны зам-уур амьсгалын бүсчлэлээр 2-р бүсэд хамаарах бөгөөд бусад нутаг дэвсгэрийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Цаг уурын үзүүлэлтийг хамгийн ойр орших Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын цаг уурын станцын олон жилийн ажиглалтын мэдээ материалд тулгуурлан тогтоолоо.

Эрдэнэцагаан өртөө 1937 оны 11-р сарын 17 -нд Эрдэнэцагаан сумын төв болох Чоно голд "Егүзэр" цаг уурын өртөө, бөмбөлөг хөөргөх салбартай хослон байгуулснаар, Сүхбаатар аймагт анхны цаг уурын өртөө байгуулагдсан байна.

2.3 Гадаргын ус

Ус зүйн сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг бөгөөд Галба Өөш Долоод говийн сав газарт багтдаг байна. Гадаргуугийн усан сүлжээний хувьд төв азийн гадагш урсгалгүй ай савд багтах бөгөөд гадаргуугийн байнгын усан сүлжээ хөгжөөгүй, газрын гадаргын усаар нэн ядмаг нутаг юм. Нутгийн иргэд ундны болон ахуйн хэрэглээний усаа гар худгаас хангадаг боловч эдгээр худгуудын ус нь хатуулаг өндөртэй, бага гүнтэй, ундарга багатай байдаг. Талбайн хэмжээнд Хөх овооны ус, Эхэн хаяаны болон Адаг хаяаны ус гэсэн гурван гар худаг байдаг. Хур тунадас ихтэй жил жижиг нуур, тойрмууд бий болох боловч бүгд намар болоход ширгэнэ. Талбайн гадна, зүүн

өмнө 2 өрөмдмөл худаг гаргасан байдаг нь өнөө хүртэл ашиглагддаг бөгөөд талбайгаас 10 км орчим зайтай өрөмдмөл худагас өрөмдлөгийн усаа зөвөрлөн авч байсан.

2.4 Газар доорхи ус

Гидрогеологийн нөхцөл


Тус район нь гидрогеологийн хувьд Монголын Дорнод говийн мужид хамаарагдах бөгөөд газар доорх усны тэжээгдэл их хомс байдаг. Хавар, зуны улиралд гадаргын уснаас зөвхөн тэжээлээ авдаг. Хөрс болон гүний усыг хүн ам болон малын бэлчээр усжуулалтаар худаг гарган ашиглаж ирсэн. Урьд өмнө хийгдсэн бэлчээр усжуулалтын усан хангамжийн зориулалттай геологийн судалгааны материалыг үндэслэн голлох ус агуулагч чулуулаг болон уст үеийн талаар товч үндэслэл тойм үнэлгээ гаргаж болно. Үүнд:

Дөрөвдөгчийн уст үе (Q): энэ уст үе давхарга нь томоохон хөндий амуудаар нил үргэлжилсэн байдлаар тархсан бөгөөд үндсэн нь аллюви, пролюви гарал үүсэлтэй байна.

Ус агуулах чулуулаг нь хайрга, элс, сайр, сайрга, бул чулуу, шавар, шавранцартай хайрга, хайрганцар зэрэг хурдас болон элсэрхэг чулуунаас тогтоно. Энэ уст үеийн зузаан нь жижиг хөндий амуудаар 5.0 м бөгөөд томоохон хөндий талаар 50 м хүртэл үргэлжилнэ. Судлахаар төлөвлөж буй районд усны хайгуул судалгааны цооног болон ашиглалтын худгаас үзэхэд усны тогтсон түвшин 5-30.0 м, энэ уст үеийн ундарга 0.5-6.0 л/сек, түвшний доошлолт 7-25 м хувийн ундарга 0.3-0.5 л/сек*м байна. Энэ уст үеийг бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар уст цэг байгуулан ашиглаж байна.

Девон Пермийн уст цогцолбор (D, P): Энэ цогцолбор нь тус районд нилээд өргөн хэмжээтэй тархсан, гүний ус агуулах чулуулгийг бүрдүүлж байна. Ус агуулагч чулуулгийн бүрдүүлэгч бүхий ан цавтай шохойн чулуу, диабаз, боржин зэргээс бүрдэнэ. Хурдасны зузаан 100 гаруй метр ба зарим газарт түүнээс дээш байна. Усны ундарга нь дөрөвдөгчийн хурдаснаас нэлээд их хэмжээтэй байдаг бөгөөд 25-30 л/сек байна. Энэ уст үеийн тэжээгдэл нь зөвхөн аллювийн хурдаснаас авдаг тул аллювийн хурдасны газар доорх ус бүрэлдэн тогтох унаган байгалийн тогтолцоог эвдэрэгдээгүй горим барьж байх нэн тэргүүний авч үзэх ёстой зүйлийн нэг гэж үзэж байна. (зураг 5)

Газар доорх усыг энэ бүсэд ул хөрсний /нүх сүвийн/, гүний /ан цавын/ гэж хоёр хуваах бөгөөд дээр өгүүлснээр ул хөрсний усыг хөдөө аж ахуй, газар тариалан малын бэлчээр, хүн амын хэрэгцээнд ашиглаж ирсэн байна. Энэ район хүн ам бага суурьшдаг тул ул хөрсний усны хэрэглээ бага, ул хөрсний усыг авч ашиглахад эргэж нөхөн сэргээгдэх горимын хүрээнд байгаа учраас газар доорх ус хүний үйл ажиллагаанаас болж хомсдох бохирдох зэрэг сөрөг нөлөөлөлд автаагүй байна. Судалгааны талбайд Дунд Палеозойн хувирмал, Юрагийн галт уулын, Доод Цэрдийн тунамал хурдас болон Юрагийн судлын чулуулаг тархана. Дунд Палеозойн хувирмал хурдас нь талбайн ихэнх хэсгээр тархах ба зүүн хойш сунаж тогтсон шаварлаг занар, элсжин, шохойн чулуу, шохойлог скарн зэрэг чулуулгуудаас бүрдэнэ.



Зураг 6. Төслийн талбайн орших сав газрын зураглал

Төслийн талбайн хувьд:

Тус гаалийн хяналтын талбайн хувьд усны хэрэглээний тухай дүгнэхдээ ахуйн болон тоосжилт дарах бага зэрэг ус хэрэглэж уг усаа дахин ашиглах бөгөөд ба харин ахуйн зориулалтаар хоногт нийт 0.6 м³, жилд 210 м³ ус хэрэглэхээр тооцоолсон.


Ундны усны шинжилгээний үр дүнгээс үзэхэд 170-160-р худаг нь Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн Цэнгэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус, 2-р худаг нь химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, III төрлийн цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Ундны усны стандарт (MNS 0900:2005)”-ын шаардлага хангаж байна.

2.5 Хөрсөн бүрхэвч

Тус төслийн талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн хотгорын бүсжилтэй нутгийн Монголын Дорнод мужийн Дарьгангын 20-р тойрогт хамаарна. (Монгол Улсын Үндэсний Атлас 2022).

Хөрсөн бүрхэвчийн тархалт

**“Чонохарайх гол” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 1-р багийн нутагт байрлах
“Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн
ТӨЛӨВЛӨГӨӨ**




Зураг 7. Төслийн хөрсөн бүрхэвчийн зураглал

Хөрсний морфологи бичиглэл

Хүснэгт 2. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Дээж-1	
Байршил	Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сум	
Координат	45°45'55.34"N 116°11'38.96"E	
Өндөр	д.т.д 870 метр	
Газрын гадарга	0-4.17°	
Ургамлын бүрхэвч	10%	
Хөрсний нэр	Цайвар хүрэн хөрс,	
Хөрсний фото	Гүн А. 0-20 20	Морфологи шинж чанар
		Цайвар хүрэн өнгийн, сийрэг, үелсэн жижиг чулуурхаг нийцтэй, чулуурхаг-40%, элсэнцэр, давсны хүчилд бургилт өгнө,шилжилт тэгш тод
Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Дээж-2	
Байршил	Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сум	
Координат	45°45'57.29"N 116°11'41.93"E	

Хөрсний морфологи бичиглэл		
Өндөр	д.т.д 865 метр	
Газрын гадарга	0-4.17°	
Ургамлын бүрхэвч	10%	
Хөрсний нэр	Цайвар хүрэн хөрс,	
Хөрсний фото	Гүн	Морфологи шинж чанар
	А. 0 -20 20	Цайвар хүрэндүү өнгийн, сийрэг, үелсэн жижиг чулуурхаг нийцтэй, чулуурхаг-30%, элсэнцэр, давсны хүчилд бургилт өгнө,шилжилт тэгш тод

Зураг 8.Хөрсний эвдрэлийн зураглал

Төсөл хэрэгжих талбайн хөрс хамгаалах талаар

Судалгааны талбайд хөрс нь янз бүрийн хэмжээнд эвдрэлийн эрчмийн хувьд их болон маш хүчтэй хэлбэрээс бусад хэлбэр судалгааны талбайд илэрсэн болно. Хөрсний эвдрэлийг бий болгогч хүчин зүйлс дийлэнх эвдрэлийн цэгт байгалийн ус, салхины эвдрэл байсан бөгөөд багахан талбайд зам болон хүний үйл ажиллагаатай холбоотой хөрсний эвдрэл тоологдсон юм.

Төслийн барилгын ажлын үед хөрсний эвдрэлийг хамгийн бага байлгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг цаг алдалгүй хийх, хатуу шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэх, зөвшөөрөгдсөн газарт хаях, шатах тослох материал асгарах зэргээс хөрс бохирдохоос сэргийлэх арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлж байх, төслийн төлөвлөгдсөн талбайгаас гадна машин техник байрлуулахгүй байх, олон салаа зам гаргуулахгүй байх тал дээр анхаарах хэрэгтэй. Мөн аюултай хог хаягдлыг тусгай

зориулалтын цементэлсэн талбайд кодлон хадгалж, тогтмол хугацаанд тээвэрлүүлж, устгуулах нь чухал.


Төсөл хэрэгжих талбайн хөрсний онцлогоос хамааран шороо тоос ихээр үүсэж агаар болон ургамлын нөмрөгт ихээр нөлөөлөх учраас авто машины зогсоолыг хатуу хучилттай болгон тохижуулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдах барилга байгууламжаас бусад талбайд стандарт (MNS6426:2013)-ын дагуу нийт талбайн 30-аас багагүй хувьд нь ногоон байгууламж байгуулах шаардлагатай.

Барилгын ажлын нөлөөгөөр эвдэгдсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж, төсөл хэрэгжих талбайд явган хүний замыг тусгайлан бэлдэхийг зөвлөж байна.

2.6 Ургамлан нөмрөг

Ботаник газар зүйн мужлалтаар төсөл хэрэгжүүлэх газар нь Дорнод Азийн дэд мужид хамаарах чийглэгдүү хэв шинжийн Нүхт давааны 30-р тойрогт хамаарагдаж байна. (Монгол Улсын Үндэсний Атлас).

Төслийн талбайн районд харгана оролцсон жижиг дэгнүүлт үетэн-хялган-шарилжит бүлгэмдэл тархсан байна.




Зураг 9. Төслийн талбайн бэлчээрийн хэв шинж

2.7 Амьтны аймаг

Тус төслийн талбай нь Монголын Дорнод талын их мужийн Халхын Дундад ба Дарьгангын талархаг мужийн ухаа гүвээт Халхын Дундад тойрогт багтана. Дорнод Монголын бүс нутаг нь өвөрмөц ургамал амьтны аймаг бүхий хялганат талын экосистем юм. Амьтны аймгийн хувьд хэдэн зуу мянгаараа сүрэглэн бэлчих дэлхийд өөр хаана ч үл тохиолдох цагаан зээр тэрчлэн хярс дагуурын огдой дагуурын зурам үлийн цагаан оготнотоодог монгол болжмор шийхнүүхэй чогчоохой зэрэг тал хээрийн унаган амьтдын амьдрах өлгий нутаг орчин ажээ. Иймээс ч дахин үл давтагдах онгон нүд алдам уудам энэ хээрийн экосистемийн зарим нутгийг Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамааруулж дархан цаазтай ба байгалийн нөөц газруудыг байгуулсан билээ.

2.8 Тусгай хамгаалалттай газар нутаг

Төсөл хэрэгжихээр төлөвлөж буй талбай нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах бөгөөд УТХГН-ын сүлжээтэй шууд давхцаагүй байна.




Зураг 10. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний зураглал

Хүснэгт 3. Төслийн талбайн ойролцоох Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

ТХГН-ийн ангилал	ТХГН-ийн нэр	Хамгаалалтад авсан огноо	Засаг захиргааны хуваарь	Төслийн талбай хүртэлх зай
БНГ	Лханчивандад уул	1965/1995	Сүхбаатар аймгий Эрдэнэцагаан сумын төвөөс зүүн урагш 75 км-т байрлана.	2.5 км
ДЦГ	Дорнод Монголын тал	1992/1995	Сүхбаатар аймгийн зүүн хэсгийг эзлэн оршино.	37 км

Дорнод Монголын тал Дархан цаазат газар:



Төв Азийн хялганат хээрийн хэв шинжийг бүрэн харуулсан, онгон байдлаа хадгалж үлдсэн жинхэнэ тал хээрийн үзэсгэлэнг зөвхөн Дорнод Монголоос үзэж болно. Цагаан зээрийн нүүдэллэн явах зам болсон газар нутаг бөгөөд ховор амьтан, ургамлын багагүй нөөцтэй. 1993 онд УИХ-ын 28 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авсан. Дорнод аймгийн зүүн урд, Сүхбаатар аймгийн зүүн хэсгийн нутгийг хамран улсын хилийн дагуу орших газар нутаг бөгөөд тэгш тал ховор, бэсрэг нам уулс, ухаа толгод, гүвээ тэдгээрийн хоорондох дэрст хоолой бүхий нутаг юм. Хамгийн өндөрлөг цэг нь Вангийн

цагаан уул бөгөөд далайн төвшнөөс дээш 1099 метр, хамгийн нам дор цэг нь Лагийн хоолойн урд хэсэг 709 метр болно. Чулуулгийн хувьд боржин, гүний чулуулаг, галт уулын бялхмал чулуулаг, шохойн чулуу, элсэн чулуулагтай.

Лхачинвандад уул Байгалийн нөөц газар:

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын төвөөс зүүн урагш 75 километрт байрлах бөгөөд



Лхачинвандад уулын байгалийн үзэсгэлэнт байдал, ой модгүй энэ ууланд нутагшин үржиж байгаа буга, бор гөрөөс, илбэнх зэрэг амьтадыг хамгаалах зорилгоор 1965 онд дархан цаазтай болгосон. Гэвч энэхүү үзэсгэлэнт уул нь байгалийн муж, газарзүйн онцлогийг бүрэн төлөөлж чадахгүй байгааг харгалзан тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн дагуу 1995 онд УИХ-ын 26 дугаар тогтоолоор байгалийн нөөц газрын ангилалд хамааруулжээ.


Лхачинвандад, Баруун Араат, Зүүн Араат зэрэг

уулс нь Монголын Дорнод тэгш талын мужийн өмнөд захад Дарьгангын галт уулт өндөрлөг, талархаг газрын зүүн залгаа орших уулт хээр нутаг юм. Эдгээр уулс нь 1200 метрээс өндөргүй, бөмбөгөр оройтой, уужуу тавиу ам хөндийтэй нам уулс юм. Нутгийн урд хэсэг нь өндөрлөг, хойшоо намхан учир өмнөөс хойшлох тутам аажмаар улам бүр намсан уул толгод, ухаа гүвээ болсоор Дорнодын тэгш тал руу алгуур нийлнэ.

Лхачинвандадын нөөц газарт буга, бор гөрөөснөөс гадна үнэг, чоно, хярс, өмхий хүрэн, дорго, цагаан зээр, тарвага зурам, үхэр огодой, туулай, чоно, сохор номин, мануул зэрэг амьтад бий. Өвөөлж, хөх цэцгий, алтан хараацай, хонин хараацай, ангир, тогоруу тоодог, хэрээ, бүргэд, харцага, ууль, шар шувуу, улаан хошуут, тагтаа, сар, ятуу, ногтруу зэрэг шувууд тааралдана. Энэ ууланд ойн буга идээшин нутагладаг нь сонин тохиолдол юм. 1886 онд Өвөр Монголын нэгэн ноёноос Егүзэр хутагтад хоёр буга бэлэг болгосныг малласаар 1905 он хүргэжээ. Буга өсөж үржээд 20 гаруй тоо толгой болсон байна. 1914-1915 оны үед Егүзэрийн буга 100 орчим болж өсөхөд тэдгээрийг хашаанаас гарган зэрлэгшүүлж зоргоор нь тавьжээ. Гэвч олон жил хүний гарт дассан тул ойролцоо нутагшиж нэг их холдохгүй байсаар байв. 1930-аад оноос хойш харьцангуй зэрлэгшин Лхачинвандад уулнаа тархаж, Зүүн Баруун Араат уулсаар ч нутаглах болжээ.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын хэмжээнд Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газар нутгийн сүлжээг доорх зургаар харуулаа. Төсөл хэрэгжихээр төлөвлөж буй талбайтай шууд давхцаж байгаа газар байхгүй байна. Төслийн талбайгаас Чулуут 31 км-т, Баруун Араат Далай булаг 36км-т оршиж байна.



Зураг 11. ОНТХГН-ын сүлжээ

Төсөл хэрэгжих талбайтай хамгийн ойр Лханчивандад уул БНГазар 2.5 км зайд, Дорнод Монголын ДЦГ 37 км-т оршиж байна. Орон нутгийн тусгай хамгаалалт бүхий Чулуут 31 км, Баруун Араат Далай булаг 36км зайд оршиж байна.

2.9 Нийгэм, эдийн засаг

Эрдэнэцагаан сум

Нутгийн хилийн нийт урт 1340 км бөгөөд урд талаараа БНХАУ-тай 485 км, баруун талаараа Дорноговь аймагтай 165 км, хойт талаараа Хэнтий аймагтай 260 км, зүүн хойт талаараа Дорнод аймагтай 430 км газраар тус тус хиллэдэг.

Аймгийн нутаг Дорнод Монголын тэгш талын өмнөд хэсгийн үргэлжлэл бөгөөд нийтдээ 82.3 мян.км² газар нутагтай, тал хээрийн бүсэд багтдаг. Нутгийн ихэнх хэсэг нь далайн түвшнээс дээш 1000 1200м өндөрт оршдог. Хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс дээш 1778 м-т өргөгдсөн Шилийн Богд уул, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 790 м-т өргөгдсөн Байшинт юм.

Байгалийн сонин тогтоц бүхий газар нутаг элбэгтэй. Үүнд: Дарьганга суманд 200 гаруй сөнөсөн галт уул, Онгон Дарьганга суманд 127-248 км² талбай эзлэх Онгон, Молцогийн их элс, Эрдэнэцагаан сумын нутагт байгалийн нөөц газар Лхачинвандад уул, Дарьганга, Наран сумын нутагт Баяндулаан, Талын агуйт, Мөнххаан сумын Баян-Уулын орчмын агуй зэрэг юм.



Сум байгуулагдсан түүх: 1924 оны 4 дүгээр сард Улсын бага хурлын шийдвэрээр Эрдэнэцагаан уулын хошуу нэртэйгээр анх байгуулагджээ. Аймгийнхаа хамгийн зүүн өмнөд хязгаарт, 17,3 мянган км.кв газар нутагтай. Тус суманд Хөндлөх хайлааст, Цагаан-Овоо, Бадрах, Хонгор, Билүүт, Жаргалант, Хадынбулаг, Алтан-Овоо гэсэн 8 багийн 6,970 хүн амьдарч байна. Халх, хуучид, үзэмчин, дарьгангачууд амьдардаг.



Газар зүйн байршил: Газар нутаг нь тал хээрийн бүст багтана. Дархан цаазат Лхачинвандад уул, Зотол хаан, Уртын цагаан овоо, Норов уул, Бяруутын баян цагаан, Чандмань уул зэрэг уулстай. Хөндлөн Хайлааст, Хэцүүгийн ам, Яам хад, Баян хайлс, Мойлтын өндөр зэрэг үзэсгэлэнт газар олонтой. Хонгор, Жаргалант, Хад, Могойн гол, Усан хөл, Чоно гол зэрэг 20 гаруй булаг, горхитой. Рашаан Цайдам, Далай булаг зэрэг рашаан устай.

Хонгорын голын алт, Чоноглын гянт болд, Нүхтийн молибден, Баянцогтын нүүрсний орд газартай. Сумын төв нь Чоно гол. Баруун-Уртаас 217 км, Улаанбаатараас 777 км

зайтай.

Газар ашиглалтын байдал: Эрдэнэцагаан сум нь аймгийнхаа хамгийн зүүн өмнөд хязгаарт орших бөгөөд 1694.8 мянган га газар нутагтай, түүний дотор хөдөө аж ахуйн эдэлбэр газар 1421.0 мянган га, тусгай хамгаалалттай газар 271.1 мянган га, усны эдэлбэр газар 545 га, зам сүлжээний газар 1542.2 га, хот суурингийн эдэлбэр газар 577.4 га-г тус тус эзэлдэг.

Газар тариалан: Газар тариалангийн үйлдвэрлэл хөдөө аж ахуйн нэгдэл тарснаас хойш зогсонги байдалд орсон. Сүүлийн жилүүдэд өрхийн төмс, хүнсний ногооны тариалалт жилээс жилд нэмэгдэж, иргэдийн идэвх санаачлага дээшилж, хүлэмжийн тариалалт хийж байна. Усалгаатай тариалан эрхлэхэд усны хангамж хүрэлцээгүй тул нэгжээс авах ургацын хэмжээ бага байдаг. Хадлангийн талбай хүрэлцээтэй, ургац сайн ч техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу тул газар тариалан зогсонги байдалтай байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ: Үйлдвэр үйлчилгээний хувьд талх, нарийн боовны цех нэг, блокны үйлдвэр 2 ажилладаг. Худалдаа, үйлчилгээний 43 цэг, салбар байдаг ба энэ нь бөөний худалдааны цэг, супермаркет, минимаркет, баар, цайны газар, кафе, мах, сүү, цагаан идээний дэлгүүр, хүнс, бараа, барилгын материал, сэлбэгийн дэлгүүр ажилладаг. Ахуйн үйлчилгээний салбарт үсчин 4, гуталчин 1, зочид буудал 4, оёдолчин 3, мужаан 4, машин, мотоциклын засвар, дугуй засварын газрууд тус тус ажилладаг.

Дэд бүтэц: Эрчим хүчний төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон ба нар, салхины эх үүсгүүр ашигладаг өрхийн тоо 700 орчим болоод байна.

Аймгийн төв болон бусад сумдтай шороон замаар холбогддог. Сумын төвд 3 км хатуу хучилттай замтай. Сумаас гадагш болон доторх ачаа, зорчигч тээврийн үйл ажиллагааг хувийн хэвшлийнхэн гүйцэтгэдэг. Аймгаас суманд 7 хоногт 2 удаа шуудангийн үйлчилгээ үзүүлдэг, багуудад шуудан хүрдэггүй.

Дэд бүтцийн хөгжил төдийлөн сайнгүй. Байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгалт газруудаа түшиглэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нөөц боломжтой.

Байгалийн баялгийг нь ашиглаад нөхөн сэргээлт хийхгүй байх асуудал байсаар байна. Сумын төв орчимд ногоон байгууламж байхгүй, шороон шуурга ихэссэн, усны нөөц багассан зэрэг нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх талтай.



Зураг 12. Эрдэнэцагаан сумын нутгийн удирдлагын ордон

Сумын статистик мэдээ:

Хүснэгт 4. Багийн өрхийн мэдээлэл, хүн ам

Сум, баг	Хүн амын тоо					Өрхийн тоо				
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2018 Он	2019 Он	2020 Он	2021 Он	2022 Он
1-р баг, Хөдлөн хайлааст	1,023	1,029	1,055	1,096	1,117	274	285	289	298	306
2-р баг, Цагаан овоо	1,084	1,081	1,111	1,100	1,091	309	300	304	327	325
3-р баг, Бадрах	706	709	731	735	762	188	185	198	204	214
4-р баг, Хонгор	592	613	627	676	694	161	164	170	181	185
5-р баг, Билүүт	1,028	1,000	990	960	887	290	264	268	258	239
6-р баг, Жаргалант	721	721	727	745	752	208	203	213	222	235
7-р баг, Хадын булаг	778	767	784	798	833	228	220	231	242	251
8-р баг, Алтан овоо	868	848	868	855	838	254	247	259	261	256
Эрдэнэцагаан	6,800	6,768	6,893	6,965	6,974	1,912	1,868	1,932	1,993	2,011

Эрдэнэцагаан сумын хүн амын өсөлт 1%-тай, тус сумын хүн амын тоо сүүлийн 5 жилд буурсан үзүүлэлтгүй байна. Нийт 2011 өрхтэй бөгөөд үүний 1069 буюу 53.1 хувь нь малчин өрх байна.

Хүснэгт 5. Багийн малчин өрхийн тоо

Сум, баг	2024 он
1-р баг, Хөдлөн хайлааст	233
2-р баг, Цагаан овоо	46
3-р баг, Бадрах	184
4-р баг, Хонгор	158
5-р баг, Билүүт	37
6-р баг, Жаргалант	165
7-р баг, Хадын булаг	198
8-р баг, Алтан овоо	48

“Чонохарайх гол” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 1-р багийн нутагт байрлах
 “Гаалийн хяналтын талбай” төслийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн
 төлөвлөгөө

Эрдэнэцагаан	1069
--------------	------

Тус сумын малын тоо толгой 2022 оны байдлаар 47681 бөгөөд үүнээс хонь 41.6 хувь буюу 198423, ямаа 38.7 хувь буюу 184422, үхэр 7.8 хувь буюу 37184, адуу 11.8 хувь буюу 56133, тэмээ 0.7 хувь буюу 651 тоо толгой бүхий байна.

Хүснэгт 6. Сумын мал аж ахуйн үзүүлэлтүүд

Сум, баг	Адуу		Үхэр		Хонь		Ямаа		Тэмээ		Нийт
	Тоо толгой	Эзлэх хувь	Тоо толгой	Эзлэх хувь	Тоо толгой	Эзлэх хувь	Тоо толгой	Эзлэх хувь	Тоо толгой	Эзлэх хувь	
Эрдэнэцагаан	56133	11.8	37184	7.8	198423	41.6	184422	38.7	651	0.7	476813

/ Эх сурвалж www.1212.mn/

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 7. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	Ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Орчны хөрс, хөрсний ус	0-0.5 га	Боломж бага	Хавар, намар, зуны улиралд
2	Зам, жим харгуй ихсэх, тоосжилт, шороон шуурга	Хөрс, ургамал	Төслийн автомашины зогсоолоос гадна машин тэрэг байрлуулах	Их	Төслийн туршид
3	Төслийн хүчин чадлаас хэтэрсэн үйлчилгээ явуулах	Орчны ургамал нөмрөг, хөрс	0-3км ²	Их	Тогтоох боломжгүй
4	Түймэр	Хүн, мал, эд хогшил, ургамал, хөрс	0-10км ² түүнээс их	Хүчтэй	Тогтоох боломжгүй

Хүснэгт 8. Гол нөлөөллийн дүн шинжилгээ


№	Нөлөөллүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Үр дагавар	Тохиолдох магадлал/давтамж	Зэрэглэл	Үнэлгээ
1	Хүнд даацын машинуудаас үүсэх тоосжилт агаар орчинг бохирдуулж болзошгүй	3-их	В-Өндөр	В3	ИХ
2	Нүүрс ачиж буулгах үед тоосжилт агаар орчинг бохирдуулж болзошгүй.	3-их	В-Өндөр	В3	ИХ
3	Нүүрс тээвэрлэх машины тоног төхөөрөмж, ялангуяа дизель түлшээр ажилладаг хүнд даацын машин, техникийн хорт утаа ялгарах зэргээр агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.	3-их	С- Болзошгүй	С3	Дунд
Дүгнэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц-аас харахад химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтийн явцад агаарын чанарт сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Нөлөөллийн үр дагаврын үнэлгээгээр нөлөөллийн 33% нь дунд, 67% нь их, байгааг үндэслэн уг төслөөс агаарын чанарт ИХ нөлөөтэй гэж үзэв.				

Эндээс үзэхэд тус төслийн эдэлбэр газар төдийгүй орчны газар нутгийг хамгаалалтад авч, авто хөсгийг зөвхөн тогтоосон замаар явуулж, үйлчлүүлэгчдийн тоог тогтоосон норм хэмжээнээс давуулахгүй байхыг үл харгалзваас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамал нөмрөгийг алдралд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдож, ургацын хэмжээ буурч, экологийн тэнцвэрт байдал алдагдахад дөхөм үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь үйлчлүүлэгчдийн хөл хөдөлгөөн ихсэх, төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр холжиж олон салаа зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах нь хөрс, усны бохирдол, ургамлан нөмрөг алдралд орон хомсдож биомассын хэмжээ багасах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах бүлэгт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

3.1 Нүүрс ачиж буулгах үеийн тоосжилтоос үүсэх гол сөрөг нөлөөлөл

Салхины хурд 10 м/с үед ачиж буулгалтаас үүсэх тоосонцрын агууламж нийт тоосны (TSP) хугацааны дундаж агууламжийн хэмжээ 500-2500мкг/м3, PM10 тоосонцор 100-1000 мкг/м3 агууламжтайгаар тархаж байна .



3.2 Барилга байгууламжийг өргөтгөн барьж ашиглалтад оруулснаас хойших үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл

- Объектын орчин тойронд хөрс, ургамлан нөмрөг элэгдэл, эвдрэлд орох
- Зам жим, барилга байгууламжийн орчны хөрс талхлагдах, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, үйлчлүүлэгчдийн тоо олширсноор агаар бохирдох
- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох зэргээр илэрнэ.

Төслийн байгууламжийг барих эхний үе шатанд объектыг байгуулах, газар шорооны ажил гүйцэтгэхэд тухайн орчны хөрс, ургамал нэн түрүүнд өртөж, явган хүний жим зам тавих, суваг шуудуу татах зэрэгт рельефийн зарим хэлбэрийн үндсэн төрх алдагдах, шинээр бичил хэлбэр бий болж, газрын хөрсний механик бүтэц, ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Ийм тохиолдолд тухайн байгууламж барих хэсгийн өнгөн хөрсийг хуулж овоолго хийж нөхөн сэргээлт болон цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах нь зүйтэй. Барилга байгууламж барих үеийн нөлөөллийн төрөл нэлээд олон байгаа хэдий ч хамрах хүрээ нь бага, эрчим нь их байна. Иймд байгууламжийг барьж дууссаны дараа нөхөн сэргээх ажлыг яаралтай хийх шаардлагатай. Ашиглалт жигдэрсний дараа орчинд үзүүлэх нөлөөллүүд нь түүний олон талт үйл ажиллагаатай уялдан хүрээгээ тэлэх магадлалтай байгаа нь ажиглагдаж байна.

Тус төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бүхий л хүрээнд авч үзвэл: хөрс дагтарших, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, голын ус болон эрэг бохирдох, хөрсний усаар дамжин гүний ус бохирдох, биомассын хэмжээ багасах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн, хорхой шавьж хордож устах, мөлхөгч, мэрэгчид, жигүүртэн шувууд дайжих, мод бут өвс ургамал механик гэмтэлд өртөх гэж үзэв.

3.3 Төсөлөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих орчимд агаарын бохирдол дунд зэрэгт байна. Энэ нутгийн агаар, ус, хөрс, ургамал байгалийн унаган төрх алдагдсан бөгөөд ялангуяа уг төсөл хэрэгжих талбай нь хүний суурьшилын бүсээс 480метр зайтай, тухайн орчимд агаар орчинд хүчтэй нөлөөлж бохирдуулах эх үүсвэр ихтэй. Гэвч төслийн үйл ажиллагаа улирлын чанартай тул суурьшлын бүсэд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байна.

Төсөл хэрэгжих орчмын агаарын бохирдлын эх үүсвэр нь барилга байгууламж барих явцад үүсэх тоосжилт, барилгажилтанд ажиллах машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ зэрэг болно.

Мөн агаарын бохирдлын гол үүсвэрийн нэг нь байгалийн хүчин зүйл болох шороон шуурга гэж болно. Чухам ийм үед л тоос, шороо ихээр дэгдэж агаар орчныг бохирдуулна.

